

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА, ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА НАРЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2020 оны 04 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар А/62-А/63-А/17

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай Г

Цөмийн энергийн тухай хуулийн 18.8, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Цөмийн энергийн комиссын дүрмийн 6.3, “Эрх олгох тухай” Цөмийн энергийн комиссын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход санал авах, санал өгөх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар /Б.Мөнхтогтох/, Тагнуулын ерөнхий газрын ажилтан /О.Дөлгөөн/, Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын газар /Э.Нямдаваа/-т тус тус даалгасугай.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА




ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА



ЦӨМИЙН ЭНЕРГИЙН
КОМИССЫН АЖЛЫН
АЛБАНЫ ДАРГА





ЦАЦРАГИЙН ҮҮСГҮҮРТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД САНАЛ АВАХ, САНАЛ ӨГӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасан цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, хадгалах, тээвэрлэх, түрээслэх, импортлох, экспортлох, цацрагийн үүсгүүрийн хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл /цаашид "тусгай зөвшөөрөл" гэх/ олгоход мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.8-д заасны дагуу Цөмийн энергийн комисс /цаашид "Комисс" гэх/-оос санал авах, санал өгөх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэхүү журамд заасан үйл ажиллагаа болон Комиссоос өгсөн саналын талаарх дэлгэрэнгүй мэдээ, тайлангаар Тагнуулын төв байгууллагыг улирал бүр хангана.

1.3. Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасан цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход санал авах, санал өгөх харилцаанд Цөмийн энергийн тухай хууль болон энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Тусгай зөвшөөрөлд санал авах

2.1. Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл олгохдоо дор дурдсаны дагуу санал авсан байна.

2.1.1. 1-2 дугаар ангиллын цацрагийн үүсгүүрийн тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой саналыг Цөмийн энергийн комиссоос;

2.1.2. 3-5 дугаар ангиллын цацрагийн үүсгүүр болон рентген аппарат, төхөөрөмжүүдэд тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой саналыг Комиссын Нарийн бичгийн дарга болон Комиссын Ажлын албанаас;

2.2. Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой санал авахад энэхүү журмын 2.4, 2.5-д заасан баримт бичгийг бүрдүүлэн Комиссын Ажлын албанд хүргүүлнэ.

2.3. Комиссын Ажлын алба энэхүү журмын 2.1-д заасан санал авах арга хэмжээг зохион байгуулна.

2.4. Энэхүү журмын 2.1.1-д заасан тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой санал авахад дараах баримт бичгийг хүргүүлнэ.

2.4.1. Үнэлгээний хуудас /Цөмийн болон цацрагийн хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үнэлгээний дүн/;

2.4.2. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;

2.4.3. Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т заасан баримт бичиг;

2.4.4. Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5-д заасан баримт бичиг;

2.5. Энэхүү журмын 2.1.2-т заасан тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой санал авахад дараах баримт бичгийг хүргүүлнэ.

2.5.1. Үнэлгээний хуудас /Цөмийн болон цацрагийн хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үнэлгээний дүн/;

2.5.2. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;

2.5.3. Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1, 19.1.2, 19.1.6, 19.1.9, 19.5-д заасан баримт бичиг;

2.5.4. Рентген аппарат, тоног төхөөрөмжийг импортлох, экспортлох тусгай зөвшөөрөл олгоход Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5 болон худалдан авах гэрээний хуулбар, эцсийн хэрэглэгчийн мэдээлэл.

Гурав. Тусгай зөвшөөрөл олгоход санал өгөх

3.1. Комиссын Ажлын албанаас энэхүү журмын 2.4-т заасан тусгай зөвшөөрлийн материалд үнэлгээ хийх бөгөөд Комиссын Нарийн бичгийн дарга нь Комиссын хуралдаанаар хэлэлцүүлж, санал авна.

3.2. Онцгой тохиолдолд 2.1.1-д заасан тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой саналыг ажлын шугамаар Комиссын гишүүдээс авч шийдвэрлэж болно.

3.3. Комиссын Ажлын албанаас энэхүү журмын 2.5-д заасан тусгай зөвшөөрлийн материалд үнэлгээ хийх бөгөөд Комиссын Нарийн бичгийн дарга үнэлгээ, баримт материалыг хянаж үзээд тусгай зөвшөөрөл олгоход санал өгнө.

3.4. Комиссын Нарийн бичгийн дарга энэхүү журмын 3.3-д заасан тусгай зөвшөөрөл олгоход өгсөн саналын талаар улирал тутам Комисст танилцуулна.

3.5. Энэхүү журмын 3.1-3.3 дахь заалтын хүрээнд шийдвэрлэсэн саналыг Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад санал авахаар ирүүлсэн баримт, бусад материалын хамт буцаан хүргүүлнэ.

3.8. Комиссоос 15.3.1, 15.3.2, 15.3.4–т заасан тусгай зөвшөөрөл олгоход саналыг 1 сарын дотор, 15.3.3–т заасан тусгай зөвшөөрөл олгоход саналыг ажлын 7 өдрийн дотор өгнө.

3.9. Комиссын Ажлын албанаас 15.3–т заасан тусгай зөвшөөрөл олгоход саналыг ажлын 5 өдрийн дотор өгнө.

Дөрөв. Бусад

4.1. Цөмийн энергийн тухай хуулийн 32.3.1-д заасан үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх үндсэн шаардлагыг хангах зорилгоор 10 жилээс их насжилттай эмчилгээ, оношилгооны рентген аппарат, төхөөрөмжийг импортлохгүй байх чиглэлийг баримтална.

4.2. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад санал авахгүй.

4.3. Хэрэв Комиссоос тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан санал өгсөн тохиолдолд Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрлийг хэрхэн шийдвэрлэсэн талаар Комиссын Ажлын албанд заавал мэдэгдэж ажиллана.

4.4. 200кВ ба түүнээс бага хүчдэл үүсгэх рентген аппарат тоног төхөөрөмжүүдийг 1 дүгээр ангиллын, түүнээс их хүчдэл үүсгэх рентген аппарат төхөөрөмжүүдийг 2 дугаар ангиллын рентген төхөөрөмжид хамруулан аюулгүй ажиллагааны шаардлагуудыг хангуулна.

---ooOoo---